

## **Найрсаг харилцаа, иж бүрэн стратегийн түншлэлийн тухай Монгол Улс, ОХУ хоорондын гэрээ**

Монгол Улс болон Оросын Холбооны Улсын хооронд 2000 онд Улаанбаатарын тунхаглал, 2006 онд Москвагийн тунхаглалд тус тус гарын үсэг зурснаар Монгол-Оросын харилцааны мөн чанарыг стратегийн түншлэлийн хэмжээнд тогтоох, Монгол Улс, Оросын Холбооны Улсын хооронд стратегийн түншлэлийг хөгжүүлэх тухай 2009 оны тунхаглал болон бусад хоёр талын суурь баримт бичиг нь Монгол Улс, Оросын Холбооны Улсын ард түмний хоорондох харилцааны бат бэх суурийг тавьсныг тэмдэглэж, түншлэл болон стратегийн харилцааны зарчимд үнэнч байхаа нотолж, хоёр талын хамтын ажиллагааны механизмд гарч буй шинэ боломжийг нээж байгаа өөрчлөлтийг анхаарч, түүхийн хувьд тогтсон тогтвортой харилцаа, нөхөрлөл болон сайн хөршийн уламжлал, хоёр улсын ард түмний хоорондын харилцан итгэлцэл, хүндэтгэлд тулгуурласан Монгол Улс, Оросын Холбооны Улс хоорондын харилцан ашигтай хамтын ажиллагааг өргөтгөх болон гүнзгийрүүлэхийг зорьж, олон улсын харилцаанд Нэгдсэн Үндэстний Байгууллагын гүйцэтгэх үүргийг бэхжүүлэхэд идэвхтэй хувь нэмэр оруулах зорилгыг баримталж, Нэгдсэн Үндэстний Байгууллагын дүрмийн зорилго, зарчим болон олон улсын эрх зүйн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, хэм хэмжээг дагаж мөрдөхөө нотолж, олон улсын болон бүс нутгийн тулгамдсан асуудлаар нийтлэг байр суурийг тогтоох болон хамтын ажиллагааг бэхжүүлэх зорилгоор олон улс, бус нутгийн тавцанд тогтмол болон нягт улс төрийн яриа хэлэлцээг урагшлуулах эрмэлзлийг харуулж, дэлхий нийтийн энх тайван, ард түмний аюулгүй байдлыг хамгаалах, бэхжүүлэх болон харилцан ойлголцол, хамтын ажиллагааны уур амьсгалыг бий болгоход хувь нэмрээ

оруулахыг хүсэж, сүүлийн жилд хүрсэн улс төрийн харилцааны өндөр түвшин болон хоёр улсын худалдаа, эдийн засаг, хүмүүнлэг, цэрэг-техникийн болон бусад салбар дахь хамтын ажиллагааны хөгжлийг анхааралдаа авч, дор дурдсан зүйлийг тохиролцов. Үүнд:

#### Нэгдүгээр зүйл

Талууд бие биеэ найрсаг, эрх тэгш, тусгаар тогтносон улс хэмээн үзэх бөгөөд өөр хоорондоо харилцан итгэлцэл, түүхийн хувьд тогтсон уламжлалт сайн хөршийн харилцаа, иж бүрэн стратегийн түншлэл болон бүх талын харилцан ашигтай хамтын ажиллагааны хүрээнд хамтран ажиллана. Талууд нь бүрэн эрхт харилцан адил байх, хүч үл хэрэглэх буюу хүч хэрэглэхээр заналхийлэхгүй байх, улсын дотоод болон гадаад хэрэгт хөндлөнгөөс үл оролцох, олон улсын маргааныг энхийн замаар шийдвэрлэх, олон улсын эрх зүйн дагуу хүлээсэн үүргээ ёсоор нь биелүүлэх, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал, хилийн халдашгүй дархан байдал, хүний эрхийг дээдлэх, ард түмний тусгаар тогтнох эрх болон тэгш эрх зэрэг олон улсын эрх зүйн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, хэм хэмжээг удирдлага болгоно.

#### Хоёрдугаар зүйл

Иж бүрэн стратегийн түншлэлийн хүрээнд Талууд улс төр, батлан хамгаалах, аюулгүй байдал, эдийн засаг, худалдаа, санхүү, хөрөнгө оруулалт, дэд бүтэц, тээвэр, харилцаа холбоо, эрчим хүч, мэдээллийн технологи, хүмүүнлэгийн харилцаа, соёл, урлаг, боловсрол, шинжлэх ухаан, техник, экологи, эрүүл мэнд, эрүүл ахуй, эпидемиологи болон харилцан сонирхсон бусад салбарт эрх тэгш, харилцан ашигтай хамтын ажиллагааг тогтвортой, урт хугацааны үндсэн дээр хөгжүүлнэ. Энэхүү зүйлд дурдсан салбарын хамтын ажиллагаа нь Тал бүрийн үндэсний хууль тогтоомж болон олон улсын үүрэг хариуцлагын дагуу хэрэгжинэ.

### Гуравдугаар зүйл

Төрөл бүрийн түвшинд тогтмол уулзалт зохион байгуулах, нэн түрүүнд дээд, өндөр түвшний уулзалтын механизмыг ашиглах болон сайжруулах, хоёр талын харилцан сонирхож буй хоёр талын харилцааны болон олон улс, бус нутгийн тулгамдсан асуудлаар санал солилцох замаар Талууд эрх тэгш, харилцан итгэлцлийн түншлэл, стратегийн хамтын ажиллагааг бэхжүүлнэ. Талууд хоёр улсын хууль тогтоох, төлөөллийн болон төрийн бусад сонгуульт байгууллагын хооронд харилцаа холбоог хөгжүүлэхэд тус дөхөм үзүүлнэ. Талууд хууль тогтоох ажиллагааны туршлага солилцох нөхцөлийг бүрдүүлнэ.

### Дөрөвдүгээр зүйл

Талууд иж бүрэн стратегийн түншлэлийн хүрээнд батлан хамгаалах болон цэрэг-техникийн салбарт харилцаа холбоогоо сайжруулах нь бус нутгийн болон дэлхийн аюулгүй байдлыг хангахад чиглэсэн чухал бүрэлдэхүүн хэсэг гэж үзнэ. Талууд бие биеийн эсрэг чиглэсэн цэрэг-улс төрийн аливаа эвсэлд оролцохгүй бөгөөд нөгөө Талын бүрэн эрхт байдал, тусгаар тогтнолын эрх ашигт харшилсан ямарваа нэгэн гэрээг гуравдагч улстай байгуулахгүй болон нөгөө Талын эсрэг чиглэсэн аливаа үйлдэлд оролцох, эсхүл ийм төрлийн үйлдлийг дэмжихээс түдгэлзэнэ. Аль ч Тал өөрийн нутаг дэвсгэрээ нөгөө Талын эсрэг түрэмгийлэл буюу аливаа хүчирхийлэл үйлдэх зорилгоор гуравдагч улсад ашиглуулахгүй Гадаадын цэрэг, цөмийн болон үй олноор хөнөөх бусад төрлийн зэвсгийг нутаг дэвсгэртээ байрлуулахгүй байх, нутаг дэвсгэрээрээ дамжуулан өнгөрүүлэхгүй байхад чиглэсэн Монгол Улсын бодлогыг Оросын Холбооны Улс хүндэтгэнэ. Оросын Холбооны Улс Монгол Улсад цэрэг-техникийн тусламж үргэлжлүүлэн үзүүлэх болно.

### Тавдугаар зүйл

Аль нэг Талын үзэж байгаагаар олон улсын энх тайванд заналхийлж, тухайн Талын аюулгүй байдлыг хөндөх эсхүл олон улсын хэмжээнд хүндрэл учруулах нөхцөл байдал үүсэх тохиолдолд

түүнийг шийдвэрлэх боломжтой арга замын талаар Талууд бие биедээ мэдээлж байна. Аль нэг Тал нь аюулгүй байдлынх нь эрх ашигт заналхийлэл учирч болзошгүй гэж үзвэл түүний хүсэлтээр нэн даруй зөвлөлдөнө.

#### Зургадугаар зүйл

Талууд зэвсэглэл, зэвсэг хураах болон үл дэлгэрүүлэх талаар хоёр талт болон олон талт хамтын ажиллагааны хүрээнд хамтран ажиллана.

#### Долдугаар зүйл

Талууд терроризм, хэт давралт, салган тусгаарлалт, үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэрэг, авлига, мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх бодис, тэдгээрийн прекурсор, зэвсэг, соёлын болон түүхийн үнэт зүйлсийг илэрхийлж буй урлагийн бүтээл болон эд зүйлийн хууль бус эргэлт, эдийн засгийн гэмт хэрэг, өмчийн эсрэг гэмт хэрэг, гэмт хэргээс олсон орлогыг хууль ёсны болгох, хууль бус цагаачлал, хүн худалдаалах, байгаль орчны гэмт хэрэг зэрэгтэй тэмцэх, түүнчлэн мэдээллийн аюулгүй байдлыг хангах салбарт хоёр талын болон олон талын хамтын ажиллагааны үндсэн дээр хамтран ажиллана. Талууд иргэн, гэр бүл, эрүүгийн хэргээр эрх зүйн туслалцааны салбарын тохиролцоог хэрэгжүүлэхэд шаардагдах нөхцөлийг бүрдүүлнэ.

#### Наймдугаар зүйл

Талууд олон улсын болон бус нутгийн тулгамдсан асуудлыг шийдвэрлэх, энх тайван, аюулгүй байдал, эдийн засгийн тогтвортой хөгжлийг хангах, хүрээлэн буй орчныг хамгаалах зэрэг дэлхийн болон бус нутгийн хэмжээний асуудлыг шийдвэрлэх үүднээс НҮБ, олон улсын бусад байгууллагын хүрээнд хоёр улсын хамтын ажиллагааг хөгжүүлэх, аль нэг Тал нь гишүүн бол эдгээр олон улс,

бүс нутгийн байгууллагад нөгөө Талаа элсэх, эсхүл үйл ажиллагаанд нь оролцоход бие биедээ дэмжлэг үзүүлнэ.

#### Есдүгээр зүйл

Талууд Евразийн орон зай болон Ази, Номхон далайн бус нутагт тогтвортой байдлыг бэхжүүлэх, найдвартай, иж бүрэн, үр дүнтэй адил тэгш, хуваагдашгүй аюулгүй байдлыг бий болгох, итгэлцэх уур амьсгал, харилцан уялдаатай ажиллах үзэл санааг хэвшүүлэх болон бүс нутгийн улсуудын хооронд эдийн засаг, соёл, хүмүүнлэгийн болон бусад салбар дахь харилцан холбоо, түүнчлэн соёл иргэншил, соёл болон шашин хоорондын яриа хэлэлцээний харилцааг хөгжүүлэхэд тус дөхөм үзүүлэх үүднээс хоёр болон олон талын үндсэн дээр хамтран ажиллана.

#### Аравдугаар зүйл

Талууд бие биедээ нээлттэй эдийн засгийн бодлого явуулж, эрх тэгш, харилцан ашигтай хамтын ажиллагааг, үүний дотор эдийн засгийн онцгой бүс байгуулж ажиллуулах, түүнчлэн энэ чиглэлд туршлага солилцох зэргээр хөгжүүлж, мөн хоёр талын худалдааг хурдацтай хөгжүүлэх, бизнесийн болон бусад аж ахуйн үйл ажиллагаанд таатай нөхцөл бүрдүүлэх, хөрөнгө оруулалтыг хөхиүлэн дэмжих, харилцан хамгаалах, иргэн, үйлдвэр болон эдийн засгийн хамтын ажиллагааны бусад субъектын хооронд төрөл бүрийн хэлбэрээр хорших болон шууд харилцаа тогтоохыг дэмжинэ. Талууд хөрөнгө оруулалтын хамтын ажиллагааг хөхиүлэн дэмжинэ.

#### Арван нэгдүгээр зүйл

Талууд нөгөө Талын нутаг дэвсгэрт байгаа хөрөнгө, бусад эд хөрөнгийн хувьд бие биенийхээ хууль ёсны эрх болон ашиг сонирхлыг хүлээн зөвшөөрч, хангана.

Арван хоёрдугаар зүйл

Талууд төмөр зам, агаарын тээвэр, авто тээвэр болон бусад төрлийн тээврийн салбарт, мөн дэд бүтцийн хамтарсан төсөл хэрэгжүүлэх, үүний дотор тээвэрлэлт болон логистикийн мэдээллийн систем, мэдээлэл холбооны технологийн салбарт харилцан ашигтай хамтын ажиллагааг хөгжүүлэхийг хөхиүлэн дэмжиж, бараа бүтээгдэхүүн, зорчигчдын саадгүй тээвэрлэлтийг хангах эрх зүй, эдийн засаг, зохион байгуулалтын нөхцөлийг бүрдүүлэхэд тус дөхөм үзүүлнэ. Дамжин өнгөрөх тээврийн үр ашгийг дээшлүүлэх, хил дамнасан тээврийн шинэ коридор байгуулах, түүний дотор авто зам болон УБТЗ-ын хүрээнд царигийн нэгдсэн стандарт 1520 мм өргөнд тулгуурласан төмөр замыг бий болгох хамтарсан ажлыг Талууд үргэлжлүүлнэ. Оросын Холбооны Улс нь Монгол Улсад далайд гарах эрхээ хэрэгжүүлэхэд нь үргэлжлүүлэн дэмжлэг үзүүлнэ. Талууд Төмөр замаар дамжин өнгөрөх ачаа тээвэрлэх нөхцөлийн тухай Монгол Улсын Засгийн газар, Оросын Холбооны Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээрийн заалтыг үндэслэн төмөр замаар дамжин өнгөрөх бараа бүтээгдэхүүний тээвэрлэлтийн өрсөлдөхүйц тарифын нөхцөлийг бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.

Арван гуравдугаар зүйл

Талууд хүрээлэн байгаа орчин, байгалийн өвийг хамгаалах, экологийн аюулгүй байдал, хил дамнасан усны шударга, зохистой ашиглалтыг хангах болон хил дамнасан бохирдлоос сэргийлэх чиглэлээр хамтын ажиллагааг хөгжүүлж, нутаг дэвсгэртээ экологийн хямрал, байгалийн гамшиг, үйлдвэрлэлийн ослоос урьдчилан сэргийлэх, хямралын хор уршгийг арилгахад бие биедээ дэмжлэг үзүүлэхийн зэрэгцээ хүн амын аж амьдралд заналхийлж болзошгүй байгалийн ба техногений гаралтай хүчин зүйлсээс үүдэлтэй онцгой нөхцөл байдлын үед харилцан тусламж үзүүлнэ. Энэ зорилгоор Талууд нэг талын буюу хоёр талын эрх ашигтай шууд холбогдох

асуудлаар мэдээлэл тогтмол солилцох бөгөөд зөвлөлдөж байна. Талууд ногоон технологи дамжуулах болон байгальд ээлтэй эрчим хүчний салбар дахь дэлхий нийтийн түншлэлийн хүрээнд хоёр талын болон олон талт түвшинд хамтын ажиллагааны бүхий л хэлбэрийг сайшааж, хөхиүлэн дэмжинэ.

#### Арван дөрөвдүгээр зүйл

Талууд хоёр улсын түүх, соёл, ёс заншлын өвөрмөц онцлогийг хүндэтгэх үндсэн дээр хүмүүнлэгийн салбарт хамтын ажиллагаа хөгжүүлнэ. Хоёр талын иргэдийн хооронд хэлхээ холбоог өргөжүүлэхэд бүх талын дэмжлэг үзүүлнэ. Аль аль Тал нь нөгөө Талын нутаг дэвсгэрт оршин суугаа иргэдийнхээ эрх, ашиг сонирхлыг хамгаалж, Талуудын хооронд хооронд байгуулсан олон улсын гэрээ, түүнчлэн олон улсын эрх зүйн Нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, хэм хэмжээний дагуу дэмжлэг үзүүлнэ.

#### Арван тавдугаар зүйл

Орчин үеийн технологийн ололт амжилтыг ашиглах, суурь болон хавсарга судалгааны салбарт хамтран ажиллах, түүний үр дүнг эдийн засаг, үйлдвэрлэлд нэвтрүүлж, үйлдвэрлэл болон шинжлэх ухаан, техникийн хорших үйл явцыг чанарын шинэ түвшинд гаргах зорилгоор инновацийн тэргүүлэх чиглэлээр хамтарсан хөтөлбөр, төсөл хэрэгжүүлэх нөхцөлийг харилцан бүрдүүлэхэд Талууд онцгой анхаарна.

#### Арван зургадугаар зүйл

Талууд боловсрол, шинжлэх ухаан, техник, соёл, урлаг, аялал жуулчлал, түүх болон соёлын өв, түүнчлэн мэдээллийн салбарт хамтын ажиллагааг өргөжүүлэн гүнзгийрүүлж, эрдэм шинжилгээний

төв, сургалт болон боловсролын байгууллага, соёлын байгууллага, хэвлэл мэдээлэл, олон нийтийн байгууллагын хооронд шууд холбоо харилцааг эрчимжүүлж, монгол, орос хэлийг түгээн сурталчлах, залуучууд болон спортын байгууллага хоорондын солилцоог хэрэгжүүлэх, ном, тогтмол хэвлэл, кино, театрын бүтээл, телевиз, радио хөтөлбөр солилцоог өргөтгөхийг дэмжих болон өөрийн улсын нутаг дэвсгэрт мэдээллийг харилцан түгээнэ.

Арван долдугаар зүйл

Талууд энэхүү гэрээний үзэл санааны дагуу болон түүнийг хэрэгжүүлэхээр Монгол Улсын аймаг, Оросын Холбооны Улсын субъектын хооронд болон бусад засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх түвшний нэгж, түүнчлэн төрийн, холимог болон хувийн өмчийн үйлдвэр, албан газар, байгууллагын хооронд бус нутаг, хил орчмын хамтын ажиллагааг цаашид хөгжүүлэхэд таатай нөхцөл тогтоон бүрдүүлэхийг дэмжиж, үр дүнтэй харилцааг хөгжүүлэн, хоёр улсын бүс нутаг хоорондын худалдаа, аж ахуй, соёл, хүмүүнлэгийн харилцааг бэхжүүлнэ.

Арван наймдугаар зүйл

Талууд энэхүү гэрээг хэрэгжүүлэх зорилгоор хамтын ажиллагааны тодорхой чиглэлээр олон улсын бусад гэрээг байгуулна. Энэхүү гэрээ нь Талуудаас бусад улстай байгуулсан хүчин төгөлдөр хоёр болон олон талт гэрээгээр хүлээсэн үүргийг хөндөхгүй.



#### Арван есдүгээр зүйл

Энэхүү гэрээний заалтыг тайлбарлах, эсхүл хэрэглэхтэй холбоотой маргааныг Талууд хоорондын сайн санааны дагуу зөвлөлдөх болон хэлэлцээ хийх замаар шийдвэрлэнэ. Маргаантай асуудлыг энд заасан арга замаар зохицуулах боломжгүй бол НҮБ-ын дүрмийн дагуу маргаантай асуудлыг эв зүйгээр зохицуулах бусад аргыг сонгож болно.

#### Хорьдугаар зүйл

Энэхүү гэрээг хугацаагүйгээр байгуулсан бөгөөд хэлэлцэн тохиролцогч Талуудын тохиролцсоноор нэмэлт, өөрчлөлт оруулж болно.

#### Хорин нэгдүгээр зүйл

Энэхүү гэрээг соёрхон батлах бөгөөд Батламж жуух бичиг солилцсон өдрөөс хүчин төгөлдөр болно. Энэхүү гэрээ хүчин төгөлдөр болох өдрөөс эхлэн Москва хотноо 1993 оны нэгдүгээр сарын 20-нд байгуулсан Найрсаг харилцаа, хамтын ажиллагааны тухай Монгол Улс, Оросын Холбооны Улс хоорондын гэрээний үйлчлэл дуусгавар болно. Энэхүү гэрээг Улаанбаатар хотноо монгол, орос хэлээр тус бүр хоёр хувь үйлдсэн бөгөөд хоёр эх бичвэр нь адил хүчинтэй байна.

*Улаанбаатар хот, 2019 оны 9 дүгээр сарын 3*  
*Эх сурвалж: <http://www.ubchamber.mn/pages/4580>*